МОНГОЛ УЛС
**ЁС ЗҮЙН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 13 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.7 дахь заалт, Ес зүйн хорооны 2024 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн хорооны Ажлын албаны үйл ажиллагааны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.3.8 дахь хэсэг, 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ёс зүйн хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар батласугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд Ажлын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулж боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган үр дүнг улирал бүр тайлагнаж ажиллахыг Ажлын алба (Н.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.АМАРТӨГС

15250100

Ёс зүйн хорооны 2025 оны 01
дүгээр сарын 13-ны өдрийн 02
дугаар тогтоолын хавсралт

# ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2024 | Зорилтот түвшин | Хугацаа /сараар/ | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО НЭГ: ЁС ЗҮЙТ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ТӨР, ИРГЭН, ОЛОН НИЙТ, ХУВИЙН ХЭВШИЛ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | |
| 1.1 | Ёс зүйт төрийн албыг төлөвшүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага болон олон улсын байгууллагын дэмжлэг, оролцоог бий болгох хамтын ажиллагааг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь | 2 | 100 | II -XII | Гишүүд, Ажлын алба |
| 1.2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, соёлыг хэвшүүлэх, чиглүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.<br>- Сургагч багшийн хөтөлбөр боловсруулах;<br>- Сургагч багш бэлтгэх;<br>Танхимын болон цахим сургалтыг зохион байгуулна. | Сургагч багшийн тоо, Сургалтын тоо | - | 60 багш, 60-аас доошгүй сургалт | I-III,<br>IV-XI | Гишүүд, Соён гэгээрүүлэх хэлтэс |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ХОЁР: ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙТЭЙ АЖИЛЛАХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ОЛОН НИЙТИЙН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | |
| 2.1 | Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах, төлөв байдлыг тодорхойлох судалгааг жил бүр зохион байгуулж, зөрчлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, үр дүнг бодлого үйл ажиллагаандаа тусгаж ажиллана. | Судалгааны үр дүнд суурилсан бодлого, шийдвэр батлагдана. | Судалгааны арга зүй, асуулга бэлэн болж, туршсан | Тайлан – 1<br>Зөвлөмж - 1 | I-IX | Гишүүд, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс |
| 2.2 | Байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал баталж, төрийн байгууллага үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Батлагдсан үнэлгээний аргачлал | - | 1 | I-VI | Гишүүд, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Ёс зүйн индексийн шалгуур үзүүлэлтийг боловсруулан баталж, индекс нэвтрүүлэх суурь нөхцлийг бүрдүүлнэ. | Батлагдсан индекс | - | 1 | I-IV | Гишүүд, Соён гэгээрүүлэх хэлтэс |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ГУРАВ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛНЭ.** | | | | | | |
| 3.1 | Ёс зүйн бүртгэл, хяналтын дэд системд нэмэлт хөгжүүлэлт хийж, гомдол мэдээлэл гаргагч шийдвэрлэлтийн явцыг хянах, мэдээлэл лавлагааг авах, статистик мэдээ, тайлан бүрэн гарах нөхцөлийг бүрдүүлнэ. | Цахим систем хөгжүүлэлтийн гүйцэтгэлийн хувь | Цахим систем нэвтэрсэн | 100 | I-XII | Гишүүд, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс |
| 3.2 | Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороо, Ажлын албаны эрх зүйн байдлыг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн талаар санал боловсруулж УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргэнэ. | Хүргүүлсэн төслийн саналын тоо | 2 | 2 | I-XII | Гишүүд, Захиргаа, эрх зүйн хэлтэс |
| 3.3 | Ёс зүйн төлөвшил, зан үйлийн хэв маягийг тодорхойлох сорил, үнэлгээний үзүүлэлтийг төрийн албан хаагчийн албан тушаалын сонгон шалгаруулалтын агуулгад тусгана. | Сорил үнэлгээний үзүүлэлт агуулгад туссан байна. | | 1 | I-III | Гишүүд, Ажлын алба |
| 3.4 | Төрийн албаны удирдах албан тушаалын томилгооны сонсголд оролцогч этгээдийн ёс зүйн хариуцлагын талаарх мэдүүлэг, санал гаргах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ. | Боловсруулсан баримт бичгийн тоо | | 1 | I-III | Гишүүд, Захиргаа, эрх зүйн хэлтэс |
| 3.5 | Төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтанд тавигдах ёс зүйн манлайллын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, үнэлэх тогтолцоог бий болгоно. | Судалгааны үр дүн | | 1 | I-III | Гишүүд, Захиргаа, эрх зүйн хэлтэс |
| 3.6 | “Төрийн албаны үнэт зүйл, удирдлагын манлайлал” зөвлөгөөнийг зохион байгуулж, төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтан, удирдах албан тушаалтныг хамруулна. | Зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн биелэлтийн хувь | 100 | 100 | I - XII | Гишүүд, Соён гэгээрүүлэх хэлтэс |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ДӨРӨВ: ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГА ХЭВШСЭН, ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.** | | | | | | |
| 4.1 | Гадаад улсын ижил төстэй байгууллагуудтай харилцааг шинээр тогтоож, тэдгээрийн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлнэ. | Хамтарч ажилласан ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | 100 | I-XII | Гишүүд, Ажлын алба |
| 4.2 | Хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хуульд заасан хугацаанд тайлагнана. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | 1 | 1 | I-XII | Гишүүд, Захиргаа, эрх зүйн хэлтэс |

---oOo---